

Инверс

$A=\{a_1, a_2, \dots, a_n\}$ ба $B=\{b_1, b_2, \dots, b_m\}$ гэсэн хоёр натурал тоон дараалал өгөгдөв. А дараалалд В дарааллын элементүүдийг нэмж $C=\{c_1, c_2, \dots, c_{n+m}\}$ дараалал үүсгэе. Үүнд А дарааллын элементүүдийн байрлалыг өөрчлөхгүй. Харин В дарааллын элементүүдийг А дарааллын эхэнд, дунд төгсгөлд хаана ч байрлуулж болно. В дарааллын элементүүдийг А дараалалд яаж байрлуулснаас хамааран С дарааллын инверс нь өөр өөр болно. Даалгавар: С дарааллын инверс нь хамгийн багадаа хэд боломжтой вэ?

Оролт: Хэд хэдэн тестээс тогтоно. Эхний мөрөнд тестийн тоо Т ($1 \leq t \leq 104$) байрлана. Тест бүр нь гурван мөрнөөс тогтоно. Эхний мөрөнд А,В дарааллын элементийн тоо n, m ($1 \leq n, m \leq 106$), 2-р мөрөнд А дарааллын элементүүд, 3-р мөрөнд В массивын элементүүд тус тус байрлана. Дарааллын элементүүд 109 -ээс хэтрэхгүй.

Гаралт: Тест бүрийн инверсийн тоог илэрхийлэх Т ширхэг тоо нэг нэг мөрөнд оршино.

Жишээ

Оролт:

3

3 4

1 2 3

4 3 2 1

3 3

3 2 1

1 2 3

5 4

1 3 5 3 1

4 3 6 1

Гаралт:

0

4

6

-Эхний тест: $C = \{1, 1, 2, 2, 3, 3, 4\}$

-Хоёр дугаар тест: $C = \{1, 2, 3, 2, 1, 3\}$

-Гуравдугаар тест: $C = \{1, 1, 3, 3, 5, 3, 1, 4, 6\}$